



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/58

Хэрлэн сум

Батлан хамгаалах хууль  
тогтоомжийг сурталчлахад хөрөнгө зарцуулсугай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4, 8.2.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн иргэд, хүүхэд залуучуудад Батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах зорилгоор сумдад орон нутгийн хамгаалалтын сургалтын танхим байгуулахад 1,494,000 (нэг сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн бүртгэл сургууль, цугларалт, зориулалтын бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын  
2024 оны 10 дугаар сарын 21 -ны өдрийн  
138 дугаар тушаалын хавсралт

### ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Үйл ажиллагаа	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хянасан
1.	Хууль, тогтоомжийн самбар хийх 18 суманд 2 ширхэг	36	40000	1.440.000	
2.	Никел хүрээ	36	1500	54000	
3.					
	Нийт			1,494,000	